



ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ

ЗАСАГЛАЛЫН ӨӨРИЙН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

- 2021 -

Улаанбаатар хот

2022 он

info.gobi.mn

АГУУЛГА

❖ Засаглалын үнэлгээний аргачлал	3
❖ Засаглалын үнэлгээний нэгдсэн дүн	4
❖ Засаглалын үнэлгээний дэлгэрэнгүй дүн	5
❖ Засаглалын үнэлгээнд хийсэн дүгнэлт	17
❖ Цаашид компанийн засаглалыг сайжруулахад авах арга хэмжээ	27

ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Монголын хөрөнгийн биржээс батлан гаргасан Хувьцаат компаниудад зориулсан “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний асуулга” буюу компани өөрийгөө үнэлэх асуулгыг ашиглан Засаглалын өөрийн үнэлгээг хийсэн.

Энэхүү үнэлгээний асуулт нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн эрх ба хувьцаа эзэмшигчдийн хурал
2. Хувьцаа эзэмшигчдийн ижил тэгш байдал
3. Оролцогч талууд
4. Ил тод нээлттэй байдал
5. Төлөөлөн удирдах зөвлөл
6. Гүйцэтгэх удирдлага гэсэн 6 үндсэн үзүүлэлт бүхий нийт 100 асуултаас бүрдсэн.

Асуулт бүрийн хүрээнд хийгдвэл зохих ажлын хэрэгжилтийг 0-2 оноогоор үнэлж түүнийгээ хувьд шилжүүлэн, үнэлгээг 0-100 хувиар тооцож гаргасан болно.

Бид 2017 оноос эхлэн энэхүү үнэлгээг хийж, үр дүнгээ олон нийтэд нээлттэй тайлагнаж ирсэн бөгөөд үнэлгээгээ илүү үр дүнтэй болгох зорилгоор 2019 оноос эхлэн асуулт бүрийг бичиг баримтын бүрдэл болон түүний хэрэгжилт гэсэн үзүүлэлтээр давхар үнэлж дундаж утгаар нь дүгнэдэг болсон.

Энэхүү асуултууд нь хувьцаат компанийн зайлшгүй баримтлах ёстой сайн засаглалын нийтлэг зарчим, Монгол улсын Компанийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Компанийн засаглалын кодексийн холбогдох заалтуудын хэрэгжилтийг үнэлэх зорилготой юм.

Засаглалын өөрийн үнэлгээг компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хийсэн бөгөөд 2022 оны 1 сарын 17-ны өдрийн Нэр дэвшүүлэх хорооны хурал, 2022 оны 1 сарын 25-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар тус тус хэлэлцэн, ТУЗ-ийн гишүүдийн саналыг тусгасны үндсэн дээр ТУЗ-ийн дарга хянаж баталсан болно.

ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

Говь ХК нь Засаглалын өөрийн үнэлгээг 5 дахь жилдээ хийж байна. Үнэлгээг хийхдээ дээрх аргачлалд дурдсан зургаан үндсэн зарчмын хүрээнд боловсруулсан 100 асуултын бичиг баримтын бүрдэл болон хэрэгжилтийг үндэслэн 0-2 оноогоор тус тус үнэлж, асуулт бүрд авсан оноог хувьд шилжүүлэн дундаж утгаар нь тооцоолон гаргасан болно.

Хүснэгт 1. Говь ХК-ийн засаглалын үнэлгээний нэгдсэн дүн

№	Үндсэн зарчмууд	Асуултын тоо	Авбал зохих оноо	Бодит үр дүн /2021 он/				Хэрэгжилтийн хувь /Сүүлийн 3 жил/		
				Бичиг баримт		Хэрэгжилт		2019	2020	2021
				Авсан оноо	Хувь	Авсан оноо	Хувь			
А	Хувьцаа эзэмшигчдийн эрх ба хувьцаа эзэмшигчдийн хурал	20	40	38	95.0%	34	85.0%	83.8%	86.3%	90.0%
Б	Хувьцаа эзэмшигчдийн ижил тэгш байдал	10	20	20	100.0%	19	95.0%	95.0%	95.0%	97.5%
В	Оролцогч талууд	10	20	19	95.0%	17	85.0%	80.0%	87.5%	90.0%
Г	Ил тод нээлттэй байдал	20	40	39	97.5%	34	85.0%	88.8%	91.2%	91.2%
Д	Төлөөлөн удирдах зөвлөл	30	60	59	98.3%	54	90.0%	85.9%	87.5%	94.2%
Е	Гүйцэтгэх удирдлага	10	20	19	95.0%	17	85.0%	82.5%	87.5%	90.0%
	Нийт	100	200	194	97.0%	175	87.5%	86.0%	89.2%	92.2%

Хүснэгт 1-д үзүүлсэн нэгдсэн дүнгээс харахад Говь ХК-ийн 2021 оны засаглалын нэгдсэн үнэлгээ нь 92.2% буюу өмнөх оноос 3% өссөн үзүүлэлттэй гарсан байна.



Бичиг баримтын бүрдлийн хувьд бүх үзүүлэлт нь 95%-иас дээш үр дүнтэй гарсан бөгөөд дундаж үнэлгээ нь 97% байна.

Харин хэрэгжилтийн хувьд дунджаар 87.5%-тай байгаа бөгөөд үүнээс 90%-иас доош хэрэгжилттэй байгаа үзүүлэлт нь:

- Хувьцаа эзэмшигчдийн эрх ба хувьцаа эзэмшигчдийн хурал
- Оролцогч талууд
- Ил тод нээлттэй байдал
- Гүйцэтгэх удирдлага гэсэн үзүүлэлтүүд байна.

ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ДҮН

Хүснэгт 2. Говь ХК-ийн засаглалын үнэлгээний дэлгэрэнгүй дүн

 Бичиг баримтын бүрдэл
 Хэрэгжилт

No.	Асуулт	Үгүй 0	Зарим 1	Бүрэн 2	Тайлбар	Нотлох баримт
A	Хувьцаа эзэмшигчдийн эрх ба хувьцаа эзэмшигчдийн хурал				Нийт 40 онооноос 36 оноо: Бичиг баримтын бүрдэл 38 оноо Хэрэгжилт 34 оноо	
A.1	ХЭ-гчид компанийн засаглалын кодекст заасан үндсэн болон бусад эрхүүдийг бүрэн эдлэх нөхцөл боломжоор хангагдсан уу?		1		ХЭ-гчдийг эрхээ эдлэх нөхцөл боломжоор хангадаг. Цаашид тогтмол сайжруулалт хийх шаардлагатай.	Компанийн дүрэм, ХЭХ-ын журам
			1			
A.2	Компанийн засаглалын кодекст заасан компанийн чухал асуудлуудыг ХЭХ-аар шийдвэрлэж байхаар дүрэмдээ тусгасан уу?		1		Компанийн тухай хуулинд заасан ХЭ-гчдийн бүрэн эрхэд хамаарах бүх асуудлыг ХЭХ-аар хэлэлцэх тухай дүрэмд тусгасан. /КЗК-ын 4.1.3-р заалтууд бүрэн тусгагдаагүй байна./	Компанийн дүрэм
			1			
A.3	Компани хийж буй их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хянах боломж нөхцөлөөр ХЭ-гчдийг хангадаг уу?		1	2	Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар үйл ажиллагааны тайландаа тайлагнах тухай журамдаа тусган, хэрэгжилтийг хангадаг.	Компанийн дүрэм, Мэдээллийн үйл ажиллагааны журам, Компанийн үйл ажиллагааны тайлан
			1			
A.4	ТУЗ-ийн гишүүний нэрийг дэвшүүлэх болон чөлөөлөх эрхийг хэрэгжүүлэх боломж нөхцөлөөр ХЭ-гчдийг хангасан уу?		1	2	Энэхүү эрхээ хэрэгжүүлэх боломжоор бүрэн хангадаг. /НДХ-ны дүрмийн 4.1.3 заалт бүрэн хэрэгжээгүй/	Компанийн дүрэм, Нэр дэвшүүлэх хорооны дүрэм, ХЭХ-ын журам
			1			
A.5	ХЭ-гчид компанийг хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрхтэй юу?			2	Энэхүү эрхээ хэрэгжүүлэх боломжоор бүрэн хангадаг.	Компанийн дүрэм, ХЭХ-ын журам
				2		
A.6	Ногдол ашгийн бодлого, ногдол ашиг тодорхойлох журамтай юу?			2	Ногдол ашгийн бодлогыг агуулсан журамтай.	Ногдол ашгийн журам
				2		
A.7	Сүүлийн 3 жилд ногдол ашиг хуваарилсан уу?		1	2	Жил бүр тогтмол ногдол ашиг хуваарилсаар ирсэн хэдий ч сүүлийн 2 жил ногдол ашиг зарлаагүй.	ТУЗ-ийн шийдвэр, ХЭХ-ын хурлын тэмдэглэл, Ногдол ашгийн тайлан
			1			
A.8	ХЭХ-ыг санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор багтаан хуралдуулдаг уу?			2	Жил бүрийн 4-р сард ХЭХ-ыг хуралдуулдаг.	ТУЗ-ийн шийдвэр, ХЭХ-ын тэмдэглэл, хурлын зар мэдээ, мэдэгдэл
				2		
A.9	ХЭХ-ыг зарлан хуралдуулах журамтай юу?			2	ХЭХ-ын журамтай.	ХЭХ-ын журам
				2		

No.	Асуулт	Үгүй 0	Зарим 1	Бүрэн 2	Тайлбар	Нотлох баримт
A.10	ХЭХ-ын зарыг зохистой хэлбэрээр хүргэдэг үү?			2	ХЭХ-ын журамд заасны дагуу хурлын зарыг зохих хэлбэрээр хүргэдэг.	ХЭХ-ын журам, И-мэйл, цахим хуудас, ТВ, өдөр тутмын сониноор зарласан.
				2		
A.11	ХЭХ-ын материалыг зохистой хэлбэрээр хүргэж, хурлаар хэлэлцэх асуудлыг судалж танилцах нөхцөл бололцоогоор хангадаг уу?			2	ХЭХ-ын журамд заасны дагуу хурлын материалыг зохих хэлбэрээр хүргэж, танилцах боломжоор хангадаг.	ХЭХ-ын журам, Хурлын материалыг ҮЦК-иуд руу цахимаар хүргүүлэхээс гадна хэвлэмэл хэлбэрээр ҮЦК-иар дамжуулан тараасан. Компанийн цахим хуудсанд байршуулсан.
				2		
A.12	Компанийн удирдах албаны хүмүүст олгосон шагнал урамшууллыг ХЭХ-д тайлагнаж хэлэлцдэг үү?			2	Жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайланд ерөнхий дүнгээр тусгадаг.	Мэдээллийн үйл ажиллагааны журам, Компанийн үйл ажиллагааны тайлан
			1			
A.13	Компанийн саналын эрхтэй хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигч нь ХЭХ-ын хөтөлбөрийн хэлэлцэх асуудалд нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой юу?			2	ХЭ-гчдийг энэхүү эрхээ хэрэгжүүлэх боломжоор бүрэн хангадаг.	Компанийн дүрэм, ХЭХ-ын журам
				2		
A.14	ХЭХ-ыг долоо хоногийн амралтын өдрүүдэд зохион байгуулдаг уу?			2	2021 оны ХЭХ-ыг хагас сайн өдөр зохион байгуулсан.	ХЭХ-ын журам, ХЭХ-ын тэмдэглэл, хурлын материал
				2		
A.15	Хурлаар хэлэлцэж буй асуудал тус бүрээр санал хураалт явуулдаг уу?			2	Хэлэлцэж буй асуудал тус бүрээр санал хураалтыг явуулдаг.	Компанийн дүрэм, ХЭХ-ын журам, ХЭХ-ын тэмдэглэл, тогтоол
				2		
A.16	ХЭ-гчид ХЭХ дээр хөндлөнгийн аудитороос асуулт асууж, тайлбар авах боломжоор хангагддаг уу?			2	Хөндлөнгийн аудиторын төлөөллийг ХЭХ-д оролцуулдаг.	ХЭХ-ын журам, ХЭХ-ын тэмдэглэл
				2		
A.17	ХЭХ-д компанийн жилийн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулж, хэлэлцүүлэг хийх боломж олгодог уу?			2	ХЭХ-д компанийн жилийн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулж, хэлэлцүүлдэг.	Компанийн дүрэм, ХЭХ-ын журам, ХЭХ-ын тэмдэглэл
				2		
A.18	ХЭ-гчдээс ХЭХ дээр асуулт тавьж хариулт авах хугацааг хурлын хэлэлцэх асуудалд оруулдаг уу?			2	Хурлын дэгт асуулт хариултын цаг болон санал шүүмж хэлэх цагийг тусган оруулдаг.	ХЭХ-ын хэлэлцэх асуудлын жагсаалт, ХЭХ-ын тэмдэглэл
				2		
A.19	ХЭХ-ын тооллогын комисс томилогдож, зохих журмын дагуу ажилладаг уу?			2	ХЭХ-ын тооллогын комиссыг зохих журмын дагуу ТУЗ-өөс томилдог.	ХЭХ-ын журам, Тооллогын комисс томилсон ТУЗ-ийн тогтоол, ХЭХ-ын тэмдэглэл
				2		
A.20	ХЭХ-ын тэмдэглэлийг хуульд заасан хугацаанд багтаан гаргаж хурлын даргын гарын үсэг, тамгаар баталгаажуулдаг уу?			2	ХЭХ-ын тэмдэглэлийг хуулийн хугацаанд 3 хоногийн дотор гаргаж хурлын даргын гарын үсэг, тамгаар баталгаажуулдаг.	Компанийн дүрэм, ХЭХ-ын журам, Хурлын тэмдэглэл
				2		

Но.	Асуулт	Үгүй 0	Зарим 1	Бүрэн 2	Тайлбар	Нотлох баримт
Б	Хувьцаа эзэмшигчдийн ижил тэгш байдал				Нийт 20 онооноос 19.5 оноо: Бичиг баримтын бүрдэл 20 оноо Хэрэгжилт 19 оноо	
Б.1	ХЭ-гчдийн гомдлыг хүлээж авах, барагдуулах асуудлыг холбогдох дүрэм журамд тусгасан уу?			2 2	Энэ тухай компанийн холбогдох журмуудад тусган, хэрэгжилтийг ханган ажилладаг.	Оролцогч талуудын өргөдөл санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам
Б.2	Ногдол ашгийг зохих бодлого журмын дагуу цаг хугацаанд нь ХЭ-гчдэд хялбар арга хэлбэрээр хуваарилдаг уу?			2 2	Ногдол ашгийг цаг хугацаанд нь хүндрэлгүй арга хэлбэрээр тараадаг.	Ногдол ашгийн журам, ТУЗ-ийн тогтоол, ҮЦТХТ-тэй байгуулсан гэрээ, Ногдол ашгийн тайлан
Б.3	ХЭ-гч хүссэн тохиолдолд холбогдох мэдээллээр хангах асуудлыг холбогдох журамд тусгасан уу?			2 2	Энэ тухай компанийн холбогдох журмуудад тусган, хэрэгжилтийг ханган ажилладаг.	Мэдээллийн үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
Б.4	ХЭХ-ын өмнө ХЭ-гч хүссэн тохиолдолд ХЭ-гчдийн бүртгэлтэй танилцах эрхтэй байх талаар журамд тусгасан уу?			2 2	Энэ тухай компанийн холбогдох журамд тусган, хэрэгжилтийг ханган ажилладаг.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
Б.5	ХЭХ-аас гаргасан шийдвэрийг ХЭ-гчдэд танилцуулах нөхцөл боломжоор хангасан уу?			2 2	ХЭХ-ын шийдвэрийг 1 хоногийн дотор МХБ болон компанийн цахим хуудсаар мэдээлдэг.	Мэдээллийн үйл ажиллагааны журам, ХЭХ-ын журам, МХБ болон компанийн цахим хуудас
Б.6	ХЭХ хуралдуулах шийдвэр гаргаснаас хойш хурлын товыг өөрчлөхгүй байх талаар зохицуулсан зохицуулалтыг мөрдөж ажилладаг уу?			2 2	Энэ тухай компанийн холбогдох журамд тусган, хэрэгжилтийг ханган ажилладаг.	ХЭХ-ын журам
Б.7	ХЭХ-д ХЭ-гч биеэр оролцож чадахгүй тохиолдолд хэрхэн санал өгөх талаар холбогдох журамд тодорхой тусгасан уу?			2 2	Энэ тухай журмуудад тусган, хэрэгжилтийг ханган ажилладаг.	ХЭХ-ын журам, ХЭХ зарлах тухай ТУЗ-ийн шийдвэр, Саналын хуудас
Б.8	ХЭ-гч мэдээлэл авах хүсэлтээ цахим шуудангаар ирүүлсэн тохиолдолд түүний шаардсан мэдээллийг цахимаар хүргүүлэх асуудал журамд тусгагдсан уу?			2 2	Энэ тухай компанийн холбогдох журмуудад тусган, хэрэгжилтийг ханган ажилладаг.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Оролцогч талуудын өргөдөл санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам
Б.9	Бүртгэлийн өдрөөс хойш хувьцаагаа бусдад шилжүүлсэн этгээд шинэ эзэмшигчид ХЭХ-д оролцох итгэмжлэл олгох, эсхүл шинэ эзэмшигчийн өгсөн зааврын дагуу санал өгөх эрхийг хэрэгжүүлж ажилладаг уу?			2 2	Энэ тухай компанийн холбогдох журмуудад тусган, хэрэгжилтийг ханган ажилладаг.	ХЭХ-ын журам

ЗАСАГЛАЛЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ-2021

No.	Асуулт	Үгүй 0	Зарим 1	Бүрэн 2	Тайлбар	Нотлох баримт
B.10	ХЭ-гчдийн ээлжит хурлын зар болон материалыг хувьцаа эзэмшигчдэд тэдгээрийн цахим хаягаар хүргэдэг үү?		1	2	ҮЦК-иар дамжуулан цахимаар мэдээлэл хүргэдэг.	ХЭХ-ын журам, ХЭХ-ын баримт бичиг
В	Оролцогч талууд				Нийт 20 онооноос 18 оноо: Бичиг баримтын бүрдэл 19 оноо Хэрэгжилт 17 оноо	
B.1	Компанид оролцогч талуудтай харилцах харилцааг зохицуулсан бодлого, журам байдаг уу?			2	Журам байдаг.	Оролцогч талуудын өргөдөл санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам
B.2	Оролцогч талуудын санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч барагдуулах механизм бий юу?			2	Энэ тухай компанийн холбогдох журамд тусган, хэрэгжилтийг ханган ажилладаг.	Оролцогч талуудын өргөдөл санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам
B.3	Компанийн хэмжээнд гарч буй хууль бус болон ёс зүйгүй практик ажиллагааны талаар ТУЗ-тэй шууд холбоо барих механизм бий юу?		1		ТУЗ-тэй ТУЗ-ийн дарга болон нарийн бичгийн даргаар дамжин холбоо барих тухай холбогдох дүрэм журамд тусгасан байдаг. Мөн компанийн цахим хуудсанд санал хүсэлтээ шууд илгээх боломжтой.	Компанийн ёс зүйн дүрэм, Оролцогч талуудын өргөдөл санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам, Компанийн цахим хуудас /info.gobi.mn/
B.4	Компани гаргаж буй шийдвэрүүдээ оролцогч талуудын сонирхол, эрх ашгийг харгалзан гаргадаг уу?			2	Энэ тухай компанийн Ёс зүйн дүрэмд тусган, хэрэгжилтийг ханган ажилладаг.	Компанийн ёс зүйн дүрэм, ТУЗ-ийн болон Гүйцэтгэх захирлын тогтоол, шийдвэрүүд, өргөдөл гомдлын бүртгэл
B.5	Компани нь оролцогч талуудыг шаардлагатай мэдээллээр хангаж ажилладаг уу?			2	Энэ тухай компанийн холбогдох журамд тусган, хэрэгжилтийг ханган ажилладаг.	Мэдээллийн үйл ажиллагааны журам, Компанийн цахим хуудас /info.gobi.mn/
B.6	Компани оролцогчидтой гэрээ байгуулах явцад нь хяналт тавих, дүгнэх, хариуцлага тооцох үйл ажиллагааг зохицуулсан журамтай юу?			2	Энэ тухай компанийн холбогдох журмуудад тусган, хэрэгжилтийг ханган ажилладаг.	Гэрээ, хэлцэл байгуулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих журам, Худалдан авалтын бодлого, Ажил үйлчилгээ худалдан авах журам, Захиалга хүлээн авах, худалдан авах, хүлээлгэн өгөх журам, Сонгон шалгаруулах хорооны журам
B.7	Компанийн бэлтгэн нийлүүлэгчид, худалдан авагчид, гэрээ гүйцэтгэгч зэрэг гол гол харилцагч талуудын хэдэн хувь нь 3-аас дээш жил хамтарсан түншүүд байдаг вэ?		1	2	Гадаад болон дотоодын нийт харилцагч байгууллагуудын 74% нь 3-с дээш жил хамтарсан түншүүд байдаг.	Холбогдох гэрээ болон бусад баримт

Но.	Асуулт	Үгүй 0	Зарим 1	Бүрэн 2	Тайлбар	Нотлох баримт	
В.8	Компани нь оролцогч талуудтай холбоотой чухал үйл явдал /томоохон түншээ алдах, гэрээ цуцлагдах г.м/-ын мэдээллийг ХЭ-гч, ХО-гчдад мэдээлдэг үү?			2	Мэдээллийн агуулга, цар хүрээг сайжруулах шаардлагатай.	Мэдээллийн үйл ажиллагааны журам	
			1				
В.9	Компанийн ажилтнуудын санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, тэдний нийгмийн асуудал, мэргэжил мэргэшлийг дээшлүүлэх төлөвлөгөөтэй ажилладаг уу?			2	Энэ тухай холбогдох дүрэм журмуудад тусгаж өгсөн бөгөөд төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажилладаг.	Хөдөлмөрийн дотоод журам, Оролцогч талуудын өргөдөл санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам, Сургалтын төлөвлөгөө	
				2			
В.10	Компани дотооддоо үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай байх бодлогыг дэмжиж ажилладаг уу?			2	Говь ХК нь үйлдвэрчний эвлэлийн хороотой бөгөөд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг.	Захиргаа хүний нөөцийн газар болон Үйлдвэрчний эвлэлийн хорооны хамтын гэрээ	
				2			
Г	Ил тод нээлттэй байдал					Нийт 40 онооноос 36.5 оноо: Бичиг баримтын бүрдэл 39 оноо Хэрэгжилт 34 оноо	
Г.1	Компани мэдээллийн журамтай юу?			2	Журам байдаг.	Мэдээллийн үйл ажиллагааны журам	
				2			
Г.2	Хөрөнгө оруулагчтай харилцах болон нийтэд мэдээлэл хүргэх зохистой тогтолцоог бүрдүүлсэн үү?			2	Энэ тухай компанийн холбогдох журмуудад тусган, хэрэгжилтийг ханган ажилладаг.	Мэдээллийн үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Компанийн цахим хуудас, Үйл ажиллагааны тайлан	
				2			
Г.3	Хувьцаа эзэмшигчидтэй харилцах, нийтэд мэдээлэл түгээх, СЗХ болон МХБ-ээс тогтоосон журмын дагуу мэдээллийг тогтмол хүргэх чиг үүрэг бүхий ажилтантай юу?			2	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Мэдээллийн үйл ажиллагааны журам	
				2			
Г.4	ТУЗ-ийн болон компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмыг өөрийн цахим хуудас дээр байршуулан нийтэд мэдээлж ажилладаг уу?			2	Компанийн цахим хуудас дээр тогтмол мэдээлэн ажилладаг.	Мэдээллийн үйл ажиллагааны журам, Компанийн цахим хуудас /info.gobi.mn/	
				2			
Г.5	Компанийн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь өнөөгийн болон ирээдүйн хөрөнгө оруулагчдын хэрэгцээ шаардлагад бүрэн нийцэж чадсан уу?			2	Компанийн цахим хуудасны агуулгыг тогтмол сайжруулан ажиллах шаардлагатай.	Мэдээллийн үйл ажиллагааны журам, Компанийн цахим хуудас /info.gobi.mn/	
			1				

ЗАСАГЛАЛЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ-2021

No.	Асуулт	Үгүй 0	Зарим 1	Бүрэн 2	Тайлбар	Нотлох баримт
Г.6	ХЭ-гчдийн ээлжит хурлын зар мэдэгдлийг СЗХ, МХБ болон ХЭ-гчдэд цаг хугацаанд нь хүргүүлсэн үү?			2	Жил бүр цаг хугацаанд нь холбогдох журмын дагуу хүргүүлдэг.	ХЭХ-ын журам, ХЭХ-ын материал, МХБ болон компанийн цахим хуудас, өдрийн сонин, ТВ
				2		
Г.7	ХЭ-гчдийн ээлжит хурлын шийдвэрийг СЗХ, МХБ болон ХЭ-гчдэд цаг хугацаанд нь хүргүүлсэн үү?			2	Жил бүр цаг хугацаанд нь холбогдох журмын дагуу хүргүүлдэг.	ХЭХ-ын журам, ХЭХ-ын материал, МХБ болон компанийн цахим хуудас
				2		
Г.8	Компани олон улсын стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг баталж, мөрдөн ажилладаг уу?			2	ОУ-ын стандартад нийцсэн НБББББ-ыг баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг.	Говь ХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
				2		
Г.9	Компанийн санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд гарган СЗХ, МХБ-д хүргүүлж, нийтэд мэдээлдэг үү?			2	Жил бүр цаг хугацаанд нь хүргүүлж, нийтэд мэдээлдэг.	Мэдээллийн үйл ажиллагааны журам, МХБ, компанийн цахим хуудас, санхүүгийн тайлангууд
				2		
Г.10	Жилийн үйл ажиллагааны тайланг холбогдох хууль журмын дагуу гаргаж мэдээлдэг үү?			2	Үйл ажиллагааны тайланг холбогдох хууль журмын дагуу агуулгыг нь тогтмол сайжруулан бэлтгэн гаргадаг.	Мэдээллийн үйл ажиллагааны журам, МХБ, компанийн цахим хуудас, Компанийн үйл ажиллагааны тайлан
				2		
Г.11	Жилийн үйл ажиллагааны тайланд компанийн (санхүүгийн бус) үйл ажиллагаа, түүний өрсөлдөх чадвар ямар байгаа болон бусад санхүүгийн холбогдолгүй асуудлын талаар тодорхой тусгадаг уу?		1	2	Санхүүгийн болоод санхүүгийн бус үйл ажиллагааны тайланг тусгадаг. Цаашид тасралтгүй сайжруулан ажиллана.	Мэдээллийн үйл ажиллагааны журам, Компанийн үйл ажиллагааны тайлан
Г.12	Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл ил тод байдаг уу?			2	Нөлөө бүхий ХЭ-гчдийн мэдээллийг МХБ болон компанийн цахим хуудас, үйл ажиллагааны тайланд ил тодоор мэдээлдэг.	Мэдээллийн үйл ажиллагааны журам, МХБ, компанийн цахим хуудас, Компанийн үйл ажиллагааны тайлан
				2		
Г.13	Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын хувьцааны эзэмшлийн талаарх мэдээлэл ил тод байдаг уу?			2	ЭБАТ-уудын мэдээлэл болон хувьцааны эзэмшлийн мэдээллийг МХБ болон компанийн цахим хуудас, үйл ажиллагааны тайланд ил тодоор мэдээлдэг.	Мэдээллийн үйл ажиллагааны журам, МХБ, компанийн цахим хуудас, Компанийн үйл ажиллагааны тайлан
				2		
Г.14	Тухайн жилийн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний хэлцлийн талаар нийтэд мэдээлдэг үү?			2	Их хэмжээний хэлцлийн талаар үйл ажиллагааны тайланд мэдээлдэг.	Мэдээллийн үйл ажиллагааны журам, МХБ, компанийн цахим хуудас, Компанийн үйл ажиллагааны тайлан
			1			

ЗАСАГЛАЛЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ-2021

Но.	Асуулт	Үгүй 0	Зарим 1	Бүрэн 2	Тайлбар	Нотлох баримт
Г.15	Компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийн талаарх мэдээллийг жилийн тайланд тусгадаг уу?			2	Жилийн үйл ажиллагааны тайланд компанийн эрсдэлийн удирдлагын талаар тайлагнадаг.	Мэдээллийн үйл ажиллагааны журам, Компанийн үйл ажиллагааны тайлан
				2		
Г.16	Компанийн эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын талаарх мэдээллийг жилийн тайланд тусгадаг уу?			2	Үйл ажиллагааны тайланд ерөнхий байдлаар тусгадаг.	Мэдээллийн үйл ажиллагааны журам, Компанийн үйл ажиллагааны тайлан
			1			
Г.17	Компанийн засаглалын тайлан, КЗ-ын кодексийг хэрэгжүүлж байгаа эсэх тухай мэдэгдлийг жилийн үйл ажиллагааны тайланд тусгадаг уу?			2	Үйл ажиллагааны тайлангийн Компанийн засаглал бүлгийн дор эдгээр агуулгыг тайлагнадаг.	Мэдээллийн үйл ажиллагааны журам, Компанийн үйл ажиллагааны тайлан, Компанийн засаглалын өөрийн үнэлгээний тайлан
				2		
Г.18	Компанийн чухал үйл явдал, үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх мэдээллийг тухай бүр шуурхай хүргэх талаар холбогдох журамд тусгаж, хэрэгжүүлдэг үү?			2	Энэ тухай компанийн холбогдох журамд тусган, хэрэгжилтийг ханган ажилладаг. Хэрэгжилтийг тогтмол сайжруулах шаардлагатай.	Мэдээллийн үйл ажиллагааны журам, холбогдох баримтууд, МХБ, компанийн цахим хуудас
			1			
Г.19	Компани дотоод мэдээлэл ашиглан арилжаа хийж байгаа эсэхэд хяналт тавих тогтолцоог бүрдүүлсэн үү?		1		Хяналтын тогтолцоог илүү сайжруулах шаардлагатай.	Мэдээллийн үйл ажиллагааны журам, Ёс зүйн дүрэм, Компанийн ЭБАТ-ны жагсаалт
			1			
Г.20	Хөндлөнгийн аудиторыг хугацаанаас нь өмнө сольсон тохиолдолд энэ талаар нийтэд мэдээлэх тухай холбогдох журамд тусгаж ажилладаг уу?			2	Энэ тухай компанийн холбогдох журамд тусган, хэрэгжилтийг ханган ажилладаг.	Мэдээллийн үйл ажиллагааны журам, МХБ-ийн болон компанийн цахим хуудас
				2		
Д	Төлөөлөн удирдах зөвлөл				Нийт 60 онооноос 56.5 оноо: Бичиг баримтын бүрдэл 59 оноо Хэрэгжилт 54 оноо	
Д.1	ТУЗ-ийн үйл ажиллагааг зохицуулсан журамтай юу?			2	Журам байдаг.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
				2		
Д.2	ТУЗ-ийн гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлсон уу?			2	Энэ тухай холбогдох дүрэм журмуудад тусган тодорхойлсон.	Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Ёс зүйн дүрэм
				2		
Д.3	ТУЗ нь компанийн үйл ажиллагааны стратегийг тодорхойлж, удирдамж зөвлөмжөөр хангаж ажилладаг уу?			2	ТУЗ нь энэхүү үүргээ бүрэн хэрэгжүүлэн ажилладаг.	Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн хурлын тэмдэглэл
				2		

ЗАСАГЛАЛЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ-2021

Но.	Асуулт	Үгүй 0	Зарим 1	Бүрэн 2	Тайлбар	Нотлох баримт
Д.4	ТУЗ-ийн даргыг компанийн гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдээс сонгохгүй байх зохицуулалтыг холбогдох журамд тусгасан уу?			2	Энэ тухай холбогдох дүрэм журамд тусган, хэрэгжилтийг ханган ажилладаг.	Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
				2		
Д.5	ТУЗ-ийн бүрэлдэхүүн хангалттай тооны хараат бус гишүүдтэй юу?			2	Нийт 9 гишүүнээс 5 хараат бус гишүүнтэй.	Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, ХЭХ-ын тогтоол, ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл
				2		
Д.6	ТУЗ-ийн хурлын жилийн төлөвлөгөө гаргаж ажилладаг уу?			2	Оны эхний хурал дээр ТУЗ-ийн хурлын төлөвлөгөөг гарган баталж, хэрэгжилтийг ханган ажилладаг.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн хурлын төлөвлөгөө
				2		
Д.7	ТУЗ-ийн гишүүд ХЭХ-д биечлэн оролцож, ХЭ-гчдийн асуултад хариулт өгдөг байх үүргийг холбогдох журамд тусгасан уу?			2	Энэ тухай холбогдох журамд тусган, хэрэгжилтийг ханган ажилладаг.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
				2		
Д.8	Хамгийн сүүлийн ХЭХ-д ТУЗ-ийн гишүүдийн хэдэн хувь оролцсон бэ?			2	2021 оны ХЭХ-д 7 гишүүн буюу 77.8% оролцсон.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, ХЭХ-ын тэмдэглэл
			1			
Д.9	Орон тооны ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай юу?			2	Орон тооны ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн НБД-ыг томилсон ТУЗ-ийн тогтоол
				2		
Д.10	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх үүрэг, хариуцлага нь тодорхой байдаг уу?			2	Энэ тухай холбогдох журамд тусган хэрэгжилтийг ханган ажилладаг.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Ажлын байрны тодорхойлолт
				2		
Д.11	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин урамшуулал нь бусад эрх бүхий албан тушаалтныхтай ижил хэмжээнд тогтоогдсон уу?			2	Цалин эрх бүхий албан тушаалтнуудаас бага хэмжээнд тогтоогдсон, урамшуулал ижил хэмжээнд тогтоогддог.	ЭБАТ-уудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн цалин урамшууллын талаар баримтлах бодлого, Тогтоол, шийдвэр
			1			
Д.12	ТУЗ-ийн дэргэд нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороотой юу?			2	ТУЗ-ийн дэргэд Нэр дэвшүүлэх хороо болон Цалин урамшууллын хороо байдаг.	Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
				2		
Д.13	Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны үйл ажиллагааг зохицуулсан журамтай юу?			2	ТУЗ-өөс батлагдсан хороодын дүрэм байдаг.	Нэр дэвшүүлэх хорооны дүрэм, Цалин урамшууллын хорооны дүрэм
				2		

No.	Асуулт	Үгүй 0	Зарим 1	Бүрэн 2	Тайлбар	Нотлох баримт
Д.14	ТУЗ-ийн нэр дэвшүүлэх үйл ажиллагаа нь зохих журмын дагуу явагддаг уу?			2	Нэр дэвшүүлэх үйл ажиллагаа нь холбогдох журмын дагуу явагддаг. Цаашид олон нийтэд нээлттэй зарлан сонгон шалгаруулах дээр анхаарна.	Нэр дэвшүүлэх хорооны дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
			1			
Д.15	ТУЗ-д нэр дэвшүүлэх, нэр дэвшигчдээс сонголт хийх, санал хураах асуудлыг журамд бүрэн, ойлгомжтой тусгаж, журмаа ил тод болгосон уу?			2	Энэ тухай компанийн холбогдох дүрэм журамд тусган, хэрэгжилтийг ханган ажилладаг. Журмуудыг компанийн болон МХБ-ийн цахим хуудсанд ил тод байршуулсан.	Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Нэр дэвшүүлэх хорооны дүрэм
				2		
Д.16	Цалин урамшууллын хороо нь ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтанд олгох цалин урамшууллын бодлоготой юу?			2	ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг ХЭХ-аар хэлэлцэн шийдвэрлэдэг ба компанийн хэмжээнд ЭБАТ-уудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн цалин урамшууллын талаар баримтлах бодлого байдаг.	Компанийн цалин урамшууллын бодлого, ЭБАТ-уудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн цалин урамшууллын талаар баримтлах бодлого, Цалин урамшууллын хорооны хурлын тэмдэглэл
				2		
Д.17	ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг үнэлж дүгнэдэг үү?			2	Нэр дэвшүүлэх хорооноос жил бүр ТУЗ-ийн өөрийн үнэлгээг хийж дүгнэн ТУЗ-ийн хурлаар хэлэлцдэг.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Нэр дэвшүүлэх хорооны дүрэм, ТУЗ-ийн өөрийн үнэлгээний тайлан
				2		
Д.18	Тайлангийн жил дууссаны дараа ТУЗ-ийн гишүүн бүрийн үйл ажиллагаанд дүгнэлт өгч, урамшууллын хэмжээг тогтоодог уу?		1		Нэр дэвшүүлэх хорооноос ТУЗ-ийн гишүүдийн өөрийн үнэлгээний асуулгыг боловсруулан, үнэлгээг нь хэлэлцэн, дүгнэдэг.	ТУЗ-ийн гишүүдийн өөрийн үнэлгээний асуулга, Нэр дэвшүүлэх хорооны хурлын тэмдэглэл, тогтоол
			1			
Д.19	ТУЗ-ийн дэргэд Аудитын хороотой юу?			2	Эрсдэл, аудитын хороо байдаг.	Компанийн дүрэм, Эрсдэл, аудитын хорооны дүрэм
				2		
Д.20	Аудит, цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хорооны дарга нь хараат бус гишүүн байдаг уу?			2	Бүх хороодын даргаар хараат бус гишүүнийг томилдог.	Хороодын дүрэм, Хороодын гишүүдийг томилох тухай ТУЗ-ийн тогтоол
				2		
Д.21	Аудитын хороо нь компанийн санхүүгийн тайланг нягтлан шалгасан талаар дүнг хэлэлцэж дүгнэлт өгдөг үү?			2	Жил бүрийн эхний хорооны хурал дээр хөндлөнгийн аудитын тайлангийн үр дүнг хэлэлцэж дүгнэлт өгдөг.	Эрсдэл, аудитын хорооны дүрэм, Эрсдэл, аудитын хорооны шийдвэр, хурлын тэмдэглэл
				2		

ЗАСАГЛАЛЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ-2021

Но.	Асуулт	Үгүй 0	Зарим 1	Бүрэн 2	Тайлбар	Нотлох баримт
Д.22	Аудитын хороо нь компанийн дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоонд үнэлэлт дүгнэлт өгсөн үү?			2	Дотоод аудитын хэлтсийн зүгээс компанийн дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоог үнэлэн, Эрсдэл аудитын хороогоор хэлэлцэн дүгнэлт өгдөг.	Дотоод хяналтын бодлого, Эрсдэлийн удирдлагын бодлого, Эрсдэл, аудитын хорооны дүрэм, хурлын тэмдэглэл
				2		
Д.23	ТУЗ-өөс томилогддог дотоод аудитын албатай юу?			2	ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл аудитын хорооны харьяа Дотоод аудитын хэлтэстэй.	Компанийн бүтэц, ДАХ-ийн дүрэм
				2		
Д.24	Дотоод аудитын албаны тайланг ТУЗ хэлэлцэж, дүгнэлт гаргасан уу?			2	ДАХ нь үйл ажиллагаагаа Эрсдэл аудитын хороонд улирал бүр тайлагнаж, хорооны дарга ТУЗ-ийн хуралд мэдээлэл хүргэн хэлэлцэж дүгнэлт гаргадаг.	Эрсдэл, аудитын хорооны дүрэм, Эрсдэл аудитын хороо болон ТУЗ-ийн хурлын тэмдэглэл, шийдвэр
				2		
Д.25	Хөндлөнгийн аудиторыг сонгох ажиллагааг зохицуулах бодлого журамтай юу?			2	Хөндлөнгийн аудит томилох журамтай.	Компанийн дүрэм, Хөндлөнгийн аудит томилох журам, Эрсдэл, аудитын хорооны дүрэм, Хараат бус аудиторт тавигдах шалгуур
				2		
Д.26	Аудитын хороо нь хөндлөнгийн аудиторыг нэр дэвшүүлж ТУЗ-д танилцуулж ажилладаг уу?			2	Нэр дэвшүүлэх үйл ажиллагааг группээс хийдэг. Эрсдэл аудитын хорооны хурлаар хөндлөнгийн аудиторыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэн дүгнэлт гарган санал боловсруулдаг бөгөөд ТУЗ-ийн хурлаар томилдог.	Хөндлөнгийн аудит томилох журам, Эрсдэл, аудитын хорооны дүрэм
			1			
Д.27	Хөндлөнгийн аудиторыг сонгон шалгаруулсан байдал, түүний бие даасан, хараат бус байдлыг батлах баримт мэдээллийг ХЭХ-д танилцуулдаг уу?			2	Хөндлөнгийн аудиторын талаарх мэдээллийг үйл ажиллагааны тайланд тайлагнадаг. Цаашид Х.Э.Х-д танилцуулдаг болох.	Эрсдэл, аудитын хорооны дүрэм, Эрсдэл, аудитын хорооны болон ТУЗ-ийн хурлын тэмдэглэл, Жилийн үйл ажиллагааны тайлан
			1			
Д.28	ТУЗ-ийн хороо бүр тогтмол хуралддаг уу?			2	ТУЗ-ийн хороо бүр хорооныхоо дүрэмд заасан хугацаанд тогтмол хуралддаг.	Хороодын дүрэм, хурлын тэмдэглэл
				2		

No.	Асуулт	Үгүй 0	Зарим 1	Бүрэн 2	Тайлбар	Нотлох баримт
Д.29	ТУЗ-ийн хороо бүр тайлан гаргадаг уу?			2	Хороод ТУЗ-ийн хурлаар ажлын тайлангаа танилцуулахаас гадна жилийн үйл ажиллагааны тайланд ажлаа тайлагнан оруулдаг. Мөн Х.Э.Х-аар хороодын тайланг танилцуулдаг.	Хороодын дүрэм, Хороодын үйл ажиллагааны тайлан, ТУЗ-д тайлагнасан тэмдэглэл, Жилийн үйл ажиллагааны тайлан, Х.Э.Х-ын тэмдэглэл
				2		
Д.30	ТУЗ-ийн ёс зүйн кодексийг батлан мөрддөг үү?			2	Компанийн ёс зүйн дүрэмд энэ тухай тусгасан бөгөөд мөрдөн ажилладаг.	Компанийн ёс зүйн дүрэм
				2		
Е	Гүйцэтгэх удирдлага					Нийт 20 онооноос 18 оноо: Бичиг баримтын бүрдэл 19 оноо Хэрэгжилт 17 оноо
Е.1	Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг зохицуулсан тусгай журам заавартай юу?			2	Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг Менежментийн гэрээ болон журмаар зохицуулдаг.	Компанийн дүрэм, Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан Менежментийн гэрээ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам
				2		
Е.2	Гүйцэтгэх удирдлага холбогдох журмын дагуу үйл ажиллагааны үр дүнг тогтмол тайлагнадаг уу?			2	Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-ийн хуралд тогтмол үйл ажиллагаа болон санхүүгийн үр дүнг тайлагнадаг.	Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан Менежментийн гэрээ, ТУЗ-ийн хурлын тэмдэглэл
				2		
Е.3	ТУЗ-өөс удирдлагын багийн үйл ажиллагааг үнэлэх дүгнэх журмыг боловсруулсан уу?		1		Нэр дэвшүүлэх хорооны хурлаар удирдлагын багийн ү/а-ны тайлантай танилцаж дүгнэлт өгдөг.	Нэр дэвшүүлэх хорооны дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Удирдлагын багийн гүйцэтгэлийн үнэлгээний хуудас
			1			
Е.4	Компани дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын бодлоготой юу?			2	Дотоод хяналтын болон Эрсдэлийн удирдлагын бодлоготой.	Дотоод хяналтын бодлого, Эрсдэлийн удирдлагын бодлого
				2		
Е.5	Гүйцэтгэх удирдлага сонирхлын зөрчил бүхий аливаа үйл ажиллагаанаас зайлсхийх талаар зохицуулсан зохицуулалтыг холбогдох дүрэм, журамд тусгасан уу?			2	Энэ тухай Ес зүйн дүрэм болон Менежментийн гэрээнд тусгасан байдаг.	Компанийн ёс зүйн дүрэм, Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам, Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан Менежментийн гэрээ
				2		

No.	Асуулт	Үгүй 0	Зарим 1	Бүрэн 2	Тайлбар	Нотлох баримт
E.6	Нийтэд нээлттэй бус дотоод мэдээллийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглах, задруулахыг хориглох хяналт зохицуулалтыг хэрэгжүүлдэг үү?			2	Энэ тухай холбогдох дүрэм журамд тусгасан байдаг. Хяналтын тогтолцоог улам сайжруулах шаардлагатай.	Мэдээллийн үйл ажиллагааны журам, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам, Ёс зүйн дүрэм, Нууцын тухай журам
				2		
E.7	Гүйцэтгэх удирдлагын тухайн компанийн үнэт цаасны арилжаанд оролцож буй байдлыг ил тод болгодог уу?			2	Энэ тухай үйл ажиллагааны тайланд тусгадаг.	Компанийн үйл ажиллагааны тайлан
				2		
E.8	Компани ёс зүйн дүрэмтэй юу?			2	Ёс зүйн дүрэм байдаг.	Компанийн ёс зүйн дүрэм
				2		
E.9	Гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллыг нийтэд мэдээлдэг үү?			2	Энэ тухай үйл ажиллагааны тайланд нийт удирдлагуудын цалин урамшуулалтай хамт ерөнхий байдлаар тусгадаг.	Компанийн үйл ажиллагааны тайлан
			1			
E.10	Удирдлагын залгамж халааны бодлоготой юу?			2	Залгамж халааны бодлого, журамтай.	Гүйцэтгэх удирдлагын залгамж халааны бодлогын журам, ЭБАТ-уудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн цалин урамшууллын талаар баримтлах бодлого
			1			

ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНД ХИЙСЭН ДҮГНЭЛТ


Говь ХК нь олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хувьд сайн засаглалыг хэрэгжүүлэн, улсдаа компанийн засаглалаар тэргүүлсэн үлгэр жишээ компани болохыг зорин ажилладаг.

2021 оны Засаглалын өөрийн үнэлгээний үр дүн 92.2% буюу өмнөх оноос 3% өссөн үзүүлэлттэй гарлаа. Бид өмнөх оны үнэлгээний үр дүн болон дүгнэлтэд үндэслэн 2021 онд дараах арга хэмжээг авч ажилласан нь энэхүү өсөлтөд нөлөөлсөн гэж дүгнэж байна.

- Баримт бичгийн бүрдлийг сайжруулах зорилгоор Хувьцаа эзэмшигчдийн хурлын журмыг шинэчлэн баталснаас гадна дараах бодлого, журмыг шинээр боловсруулан баталсан. Үүнд:
 - Дотоод хяналтын бодлогын баримт бичиг
 - Хөндлөнгийн аудит томилох журам
 - Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам
 - Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам
 - Гүйцэтгэх удирдлагын залгамж халааны бодлого
 - ТУЗ-ийн нэрэмжит шагнал олгох журам
- Засаглалын үйл ажиллагаа, хэрэгжилтийг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээг авч ажилласан. Үүнд:
 - Хувьцаа эзэмшигчдийн оролцоог нэмэгдүүлж эрхээ эдлэх нөхцөл боломжоор хангах зорилгоор Хувьцаа эзэмшигчдийн хурлыг амралтын өдөр зохион байгуулсан.
 - Компанийн мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг сайжруулах, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангах, оролцоог нь нэмэгдүүлэх зорилгоор олон улсын сайн туршлагыг судлан компанийн цахим хуудсыг шинэчлэн /info.gobi.mn/ олон нийтэд хүргэх мэдээллийн агуулгыг сайжруулан, санал хүсэлтийг нь хүлээн авч шийдвэрлэдэг болсон.
 - ТУЗ-ийн үйл ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулах, засаглалын үйл ажиллагаагаа улам бүр өргөжүүлэх зорилгоор ТУЗ-ийн ажлын албыг байгуулж ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон ТУЗ-ийн мэргэжилтэн гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж эхэлсэн.
 - Оролцогч талуудын эрх ашгийг ханган ажиллах, хувьцаа эзэмшигчдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэн 1,500 ажилтнаа хувьцаагаар урамшуулсан.
 - Хөндлөнгийн аудиторын сонгон шалгаруулахдаа Эрсдэл, аудитын хороогоор хэлэлцэн дүгнэлт гаргаж, ТУЗ-ийн хуралд танилцуулан баталдаг болсон.
 - Дотоод аудитын хэлтсийн зүгээс компанийн дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоо болон засаглалын гурвалсан үнэлгээг хийн, Эрсдэл аудитын хорооны хурлаар хэлэлцэн дүгнэлт өгдөг болсон.

Хүснэгт 2-ын Засаглалын үнэлгээний дэлгэрэнгүй дүнг үзүүлэлт тус бүрээр авч үзвэл:

А. Хувьцаа эзэмшигчдийн эрх ба хувьцаа эзэмшигчдийн хурал



Нийт 20 асуулттай бөгөөд 40 оноо авбал зохицоос 36 оноо авсан буюу 90% хэрэгжилттэй байна. /Өмнөх оноос 3.7% өссөн/

Асуултуудыг задаргаагаар нь авч үзвэл:

Асуулт	Бичиг баримтын бүрдэл		Хэрэгжилт		Дундаж
	Асуулт	Оноо	Асуулт	Оноо	Оноо
Бүрэн хэрэгждэг /2 оноо/	18	36	14	28	32
Зарим нь хэрэгждэг /1 оноо/	2	2	6	6	4
Хэрэгждэггүй /0 оноо/	0	0	0	0	0
Нийт	20	38 /95%/	20	34 /85%/	36 /90%/

Зарим нь хэрэгждэг:

А.1. ХЭ-гчид компанийн засаглалын кодекст заасан үндсэн болон бусад эрхүүдийг бүрэн эдлэх нөхцөл боломжоор хангагдсан уу?

- Хувьцаа эзэмшигчдийн эрхийг ханган ажиллах талаар Компанийн дүрэм, ХЭХ-ын журам гэх мэт холбогдох дүрэм журмууддаа тусган, хэрэгжилтийг нь ханган ажилладаг. Цаашид ч хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг хангах, эрхээ хэрэгжүүлэх нөхцөлөөр нь бүрэн хангахын төлөө бичиг баримт болон түүний хэрэгжилтийн хувьд улам илүү сайжруулалтуудыг хийх шаардлагатай.

А.2. Компанийн засаглалын кодекст заасан компанийн чухал асуудлуудыг ХЭХ-аар шийдвэрлэж байхаар дүрэмдээ тусгасан уу?

- Компанийн тухай хуулийн ХЭ-гчдийн бүрэн эрхэд хамаарах бүх асуудлыг ХЭХ-аар хэлэлцэх тухай дүрэмд тусгасан хэдий ч КЗК-ын 4.1.3 дахь заалтууд бүрэн тусгагдаагүй байна. Тиймээс сайн засаглалыг хэрэгжүүлж, хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг

хангах, эрхээ хэрэгжүүлэх нөхцөлөөр нь бүрэн хангахын төлөө компанийн дүрэмдээ сайжруулалт хийн хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай.

А.3. Компани хийж буй их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хянах боломж нөхцөлөөр ХЭ-гчдийг хангадаг уу?

- Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар үйл ажиллагааны тайландаа тайлагнах тухай журамдаа тусган, хэрэгжилтийг ханган ажилладаг. ХЭХ дээр танилцуулдаггүй.

А.4. ТУЗ-ийн гишүүний нэрийг дэвшүүлэх болон чөлөөлөх эрхийг хэрэгжүүлэх боломж нөхцөлөөр ХЭ-гчдийг хангасан уу?

- ТУЗ-ийн гишүүдийг сонгох чөлөөлөх тухай Компанийн дүрэм, Нэр дэвшүүлэх хорооны дүрэм, ХЭХ-ын журамд тусгасан байдаг ч Нэр дэвшүүлэх хорооны дүрмийн 4.1.3 заалт бүрэн хэрэгжээгүй байна. Цаашид ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох үйл ажиллагааг нээлттэй зарлах замаар ил тод явуулах шаардлагатай.

А.7. Сүүлийн 3 жилд ногдол ашиг хуваарилсан уу?


- ТУЗ-өөс 2018 онд “Ногдол ашгийн журам”-ыг батлан, Компанийн тухай хуулийн 47-р зүйл, Компанийн дүрмийн 8.12-д заасан нөхцөл хангагдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилах бөгөөд тухайн санхүүгийн жилд олсон цэвэр ашиг нь өмнөх жилийнхээс буураагүй тохиолдолд ногдол ашгийн хэмжээг бууруулахгүй байх бодлого баримтлан 2010 оноос хойш жил бүр тасралтгүй ногдол ашиг хуваарилсаар ирсэн. Гэвч 2019 болон 2020 онуудад компанийн санхүүгийн үр дүнгээс шалтгаалан ногдол ашиг хуваарилаагүй байна. Цаашид компанийн санхүү, үйл ажиллагааны үр дүнг харгалзан үзэж ТУЗ-ийн зүгээс ногдол ашиг хуваарилах шийдвэрийг гаргана.

А.12. Компанийн удирдах албаны хүмүүст олгосон шагнал урамшууллыг ХЭХ-д тайлагнаж хэлэлцдэг үү?


- Компанийн удирдах албан тушаалтнуудад олгосон шагнал урамшууллын хэмжээг ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны зүгээс тогтмол хянаж, дүгнэлт гарган ажилладаг. Мөн жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайландаа шагнал урамшууллын хэмжээг нь багцалсан байдлаар тайлагнадаг. ХЭХ дээр албан ёсоор танилцуулж хэлэлцүүлдэггүй.

Б. Хувьцаа эзэмшигчдийн ижил тэгш байдал

Бичиг баримтын бүрдэл



Хэрэгжилт



Нийт 10 асуулттай бөгөөд 20 оноо авбал зохицоос 19.5 оноо авсан буюу 97.5% хэрэгжилттэй байна. /Өмнөх оноос 2.5% өссөн/

Асуултуудыг задаргаагаар нь авч үзвэл:


Асуулт	Бичиг баримтын бүрдэл		Хэрэгжилт		Дундаж
	Асуулт	Оноо	Асуулт	Оноо	Оноо
Бүрэн хэрэгждэг /2 оноо/	10	20	9	18	19
Зарим нь хэрэгждэг /1 оноо/	0	0	1	1	0.5
Хэрэгждэггүй /0 оноо/	0	0	0	0	0
Нийт	10	20 /100%/	10	19 /95%/	19.5 /97.5%/

Зарим нь хэрэгждэг:

Б.10. ХЭ-гчдийн ээлжит хурлын зар болон материалыг хувьцаа эзэмшигчдэд тэдгээрийн цахим хаягаар хүргэдэг үү?

- ХЭХ-ын зарыг холбогдох хууль журмын дагуу МХБ болон компанийн цахим хуудас, өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр хүргэдэг. Хурлын материалыг МХБ болон компанийн цахим хуудсанд урьдчилан байршуулахаас гадна үнэт цаасны компаниудын цахим хаяг руу хүргүүлэх арга замаар ҮЦК дээр бүртгэлтэй хувьцаа эзэмшигч нарын цахим хуудас руу нь хүргүүлдэг. Бид цаашид хувьцаа эзэмшигчдийн цахим шуудангийн хаягийн албан ёсны бүртгэлийг тогтмол хийж, бүртгэлийн сантай болохыг хичээн ажиллана.

В. Оролцогч талууд



Нийт 10 асуулттай бөгөөд 20 оноо авбал зохихоос 18 оноо авсан буюу 90% хэрэгжилттэй байна. /Өмнөх оноос 2.5% өссөн/

Асуултуудыг задаргаагаар нь авч үзвэл:

Асуулт	Бичиг баримтын бүрдэл		Хэрэгжилт		Дундаж
	Асуулт	Оноо	Асуулт	Оноо	Оноо
Бүрэн хэрэгждэг /2 оноо/	9	18	7	14	16
Зарим нь хэрэгждэг /1 оноо/	1	1	3	3	2
Хэрэгждэггүй /0 оноо/	0	0	0	0	0
Нийт	10	19 /95%/	10	17 /85%/	18 /90%/

Зарим нь хэрэгждэг:

В.3. Компанийн хэмжээнд гарч буй хууль бус болон ёс зүйгүй практик ажиллагааны талаар ТУЗ-тэй шууд холбоо барих механизм бий юу?

- ТУЗ-тэй ТУЗ-ийн дарга болон нарийн бичгийн даргаар дамжин холбоо барих тухай “Оролцогч талуудын өргөдөл санал гомдол хүлээн авах журам”-д тусгасан байдаг. Мөн компанийн цахим хуудсанд санал хүсэлтээ шууд илгээх боломжийг бүрдүүлэн санал хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэн, хэрэгжилтийг ханган ажилладаг. Цаашид компанийн ёс зүйн дүрэм дэх энэ агуулгыг улам сайжруулан нарийвчлан тусгах шаардлагатай.


В.7. Компанийн бэлтгэн нийлүүлэгчид, худалдан авагчид, гэрээ гүйцэтгэгч зэрэг гол гол харилцагч талуудын хэдэн хувь нь 3-аас дээш жил хамтарсан түншүүд байдаг вэ?

- Гадаад болон дотоодын гол харилцагч байгууллагуудын 74% нь 3-с дээш жил хамтарсан түншүүд байдаг. Бид харилцагч түншүүдтэйгээ тогтвортой бөгөөд урт хугацаанд хамтран ажиллахыг эрхэмлэн, бизнесийн ёс зүйг сахин ажилладаг.

В.8. Компани нь оролцогч талуудтай холбоотой чухал үйл явдал /томоохон түншээ алдах, гэрээ цуцлагдах г.м/-ын мэдээллийг ХЭ-гч, ХО-гчдад мэдээлдэг үү?

- Мэдээллийн үйл ажиллагааны журмын хүрээнд олон нийтэд тухай бүр мэдээлэх үүрэг бүхий мэдээллийг цаг тухай бүр хүргэн ажилладаг. Цаашид мэдээллийн агуулга, цар хүрээгээ улам бүр сайжруулах шаардлагатай.

Г. Ил тод нээлттэй байдал



Нийт 20 асуулттай бөгөөд 40 оноо авбал зохицоос 36.5 оноо авсан буюу 91.2% хэрэгжилттэй байна. /Өмнөх онтой ижил/

Асуултуудыг задаргаагаар нь авч үзвэл:

Асуулт	Бичиг баримтын бүрдэл		Хэрэгжилт		Дундаж
	Асуулт	Оноо	Асуулт	Оноо	Оноо
Бүрэн хэрэгждэг /2 оноо/	19	38	14	28	33
Зарим нь хэрэгждэг /1 оноо/	1	1	6	6	3.5
Хэрэгждэггүй /0 оноо/	0	0	0	0	0
Нийт	20	39 /97.5%/	20	34 /85%/	36.5 /91.2%/

Зарим нь хэрэгждэг:

Г.5. Компанийн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь өнөөгийн болон ирээдүйн хөрөнгө оруулагчдын хэрэгцээ шаардлагад бүрэн нийцэж чадсан уу?

- Манай компани хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч нарыгаа компанийн засаглалтай холбоотой болон үйл ажиллагаа, санхүү үр дүнтэй холбоотой мэдээллээр цаг алдалгүй ханган ажиллахыг зорьдог бөгөөд 2021 онд компанийн цахим хуудсаа /info.gobi.mn/ шинэчлэн, хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшигч нарт хүргэх мэдээллийн агуулгаа сайжруулсан. Бид цаашид гадаад хөрөнгө оруулагч нарынхаа эрх ашгийг ханган цахим хуудас дахь мэдээллээ англи хэлээр давхар хүргэдэг болохоор зорин ажиллаж байна.

Г.11. Жилийн үйл ажиллагааны тайланд компанийн (санхүүгийн бус) үйл ажиллагаа, түүний өрсөлдөх чадвар ямар байгаа болон бусад санхүүгийн холбогдолгүй асуудлын талаар тодорхой тусгадаг уу?

- Жилийн үйл ажиллагааны тайланд компанийн санхүүгийн болон санхүүгийн бус үйл ажиллагаа, компанийн засаглал, эрсдэлийн удирдлага, тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлуудынхаа талаар цогцоор нь тусгадаг. Бид цаашид үйл ажиллагааны тайлангийнхаа агуулгыг тогтмол сайжруулан, баяжуулах тал дээр анхаарч ажиллана.

Г.14. Тухайн жилийн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний хэлцлийн талаар нийтэд мэдээлдэг үү?

- Их хэмжээний хэлцлийн талаар үйл ажиллагааны тайландаа тайлагнах тухай Мэдээллийн үйл ажиллагааны журамдаа тусган, хэрэгжилтийг ханган ажилладаг. ХЭХ дээр танилцуулдаггүй.

Г.16. Компанийн эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын талаарх мэдээллийг жилийн тайланд тусгадаг уу?

- Удирдлагын цалин урамшуулал гэсэн агуулгын дор ерөнхий байдлаар тусган оруулдаг. Хүн тус бүрээр нь дэлгэрэнгүй тусгадаггүй.


Г.18. Компанийн чухал үйл явдал, үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх мэдээллийг тухай бүр шуурхай хүргэх талаар холбогдох журамд тусгаж, хэрэгжүүлдэг үү?

- Энэ тухай компанийн Мэдээллийн үйл ажиллагааны журамд тусган, хэрэгжилтийг ханган ажилладаг. Цаашид олон нийтэд хүргэх мэдээллийн агуулгыг тогтмол сайжруулан ажиллах шаардлагатай.

Г.19. Компани дотоод мэдээлэл ашиглан арилжаа хийж байгаа эсэхэд хяналт тавих тогтолцоог бүрдүүлсэн үү?

- Дотоод мэдээллийн аюулгүй байдлыг хангах тухай компанийн Мэдээллийн үйл ажиллагааны журам болон Ёс зүйн дүрэмд тус тус тусган оруулсан байдаг. Үүнийг цаашид илүү нарийвчлан оруулах, мөн хяналтын тогтолцоог нь илүү сайжруулах шаардлагатай.

Д. Төлөөлөн удирдах зөвлөл



Нийт 30 асуулттай бөгөөд 60 оноо авбал зохицоос 56.5 оноо авсан буюу 94.2% хэрэгжилттэй байна. /Өмнөх оноос 6.7% өссөн/

Асуултуудыг задаргаагаар нь авч үзвэл:

Асуулт	Бичиг баримтын бүрдэл		Хэрэгжилт		Дундаж
	Асуулт	Оноо	Асуулт	Оноо	Оноо
Бүрэн хэрэгждэг /2 оноо/	29	58	24	48	53
Зарим нь хэрэгждэг /1 оноо/	1	1	6	6	3.5
Хэрэгждэггүй /0 оноо/	0	0	0	0	0
Нийт	30	59 /98.3%/	30	54 /90%/	56.5 /94.2%/

Зарим нь хэрэгждэг:

Д.8. Хамгийн сүүлийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд ТУЗ-ийн гишүүдийн хэдэн хувь оролцсон бэ?

- 2021.04.24-ний Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ТУЗ-ийн 7 гишүүн буюу 77.8% оролцсон.

Д.11. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин урамшуулал нь бусад эрх бүхий албан тушаалтныхтай ижил хэмжээнд тогтоогдсон уу?

- Цалин эрх бүхий албан тушаалтнуудаас бага тогтоогдсон. Урамшуулал ижил хэмжээнд тогтоогддог.

Д.14. ТУЗ-ийн нэр дэвшүүлэх үйл ажиллагаа нь зохих журмын дагуу явагддаг уу?

- ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай Компанийн дүрэм, Нэр дэвшүүлэх хорооны дүрэм, ХЭХ-ын журамд тусгасан байдаг ч Нэр дэвшүүлэх хорооны дүрмийн 4.1.3 заалт бүрэн хэрэгжээгүй байна. Цаашид ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох үйл ажиллагааг нээлттэй зарлах замаар ил тод явуулах шаардлагатай.

Д.18.Тайлангийн жил дууссаны дараа ТУЗ-ийн гишүүн бүрийн үйл ажиллагаанд дүгнэлт өгч, урамшууллын хэмжээг тогтоодог уу?

- Нэр дэвшүүлэх хорооноос ТУЗ-ийн гишүүдийн өөрийн үнэлгээний асуулгыг боловсруулан батлуулсан бөгөөд жил бүр тус шалгуур үзүүлэлтийн дагуу ТУЗ-ийн гишүүн бүрээр өөрийн үнэлгээг хийлгэн үр дүнг нь хорооны хурал дээрээ хэлэлцдэг. Дүгнэлт өгөх болон урамшууллын хэмжээг тогтоох арга барилыг илүү сайжруулах шаардлагатай.


Д.26. Аудитын хороо нь хөндлөнгийн аудиторыг нэр дэвшүүлж ТУЗ-д танилцуулж ажилладаг уу?

- Нэр дэвшүүлэх үйл ажиллагааг группээс хийдэг. Эрсдэл аудитын хорооны хурлаар хөндлөнгийн аудиторыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэн дүгнэлт гаргаж санал боловсруулдаг бөгөөд ТУЗ-ийн хурлаар томилдог.

Д.27. Хөндлөнгийн аудиторыг сонгон шалгаруулсан байдал, түүний бие даасан, хараат бус байдлыг батлах баримт мэдээллийг ХЭХ-д танилцуулдаг уу?

- Хөндлөнгийн аудиторын талаарх мэдээллийг үйл ажиллагааны тайланд тайлагнадаг. Цаашид ХЭХ дээр танилцуулдаг болох хэрэгтэй.

Е. Гүйцэтгэх удирдлага



Нийт 10 асуулттай бөгөөд 20 оноо авбал зохихоос 18 оноо авсан буюу 90% хэрэгжилттэй байна. /Өмнөх оноос 2.5% өссөн/

Асуултуудыг задаргаагаар нь авч үзвэл:

Асуулт	Бичиг баримтын бүрдэл		Хэрэгжилт		Дундаж Оноо
	Асуулт	Оноо	Асуулт	Оноо	
Бүрэн хэрэгждэг /2 оноо/	9	18	7	14	16
Зарим нь хэрэгждэг /1 оноо/	1	1	3	3	2
Хэрэгждэггүй /0 оноо/	0	0	0	0	0
Нийт	10	19 /95%/	10	17 /85%/	18 /90%/

Зарим нь хэрэгждэг:***Е.3. ТУЗ-өөс удирдлагын багийн үйл ажиллагааг үнэлэх дүгнэх журмыг боловсруулсан уу?***

- Энэ тухай заасан тусгай журам байхгүй ч хорооны дүрэмдээ тусгасан байдаг. Нэр дэвшүүлэх хорооноос удирдлагын багийн гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулахад чиглүүлэг өгч ажилладаг бөгөөд удирдлагын багийн үйл ажиллагааны тайлантай хагас жил тутам танилцаж дүгнэлт өгдөг.

Е.9. Гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллыг нийтэд мэдээлдэг үү?

- Гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллыг жилийн үйл ажиллагааны тайланд удирдлагын багийн цалин урамшуулал гэсэн агуулгын дор ерөнхий байдлаар танилцуулдаг.

Е.10. Удирдлагын залгамж халааны бодлоготой юу?

- ТУЗ-өөс батлагдсан Гүйцэтгэх удирдлагын залгамж халааны бодлого, ЭБАТ-уудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн цалин урамшууллын талаар баримтлах бодлого байдаг. Цаашид бодлогоо шинэчлэх, хэрэгжилтийг нь ханган ажиллах шаардлагатай.

ЦААШИД КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХАД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Бидний хувьд жил бүр засаглалын өөрийн үнэлгээг хийснээр цаашид сайжруулах шаардлагатай арга хэмжээгээ тодорхойлон, компанийн засаглалаа улам илүү сайжруулахад түлхэц болж өгсөөр байна. 2021 оны засаглалын үнэлгээний үр дүнд үндэслэн бид цаашид дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

- ❖ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох үйл ажиллагааг нээлттэй зарлах замаар ил тод явуулдаг болох;
- ❖ Компанийн удирдах албаны хүмүүст олгосон шагнал урамшуулал, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл, хөндлөнгийн аудиторын талаарх мэдээллийг талаар ХЭХ-д танилцуулдаг болох;
- ❖ Хувьцаа эзэмшигчдийн цахим шуудангийн хаягийн албан ёсны бүртгэлийг тогтмол хийж, бүртгэлийн сантай болон, ХЭХ-ын зар болон материалыг хувьцаа эзэмшигчдэд аль болох цахим хаягаар хүргэдэг болох, цахим харилцааны боломжит хувилбаруудыг улам сайжруулах;
- ❖ Компанийн хэмжээнд гарч буй хууль бус болон ёс зүйгүй практик ажиллагааны талаар ТУЗ-тэй шууд холбоо барих механизмын талаар компанийн ёс зүйн дүрэм дэх агуулгыг улам сайжруулан нарийвчлан тусгах, хэрэгжилтийг ханган ажиллах;
- ❖ ЭБАТ-уудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг шинэчлэх;
- ❖ Мэдээллийн үйл ажиллагааны журмын хэрэгжилтийг ханган мэдээллийн агуулга, цар хүрээгээ улам бүр сайжруулах;
- ❖ Олон улсын сайн туршлагыг судалж, гадаад хөрөнгө оруулагч нарынхаа эрх ашгийг ханган цахим хуудас дахь мэдээллээ англи хэлээр давхар хүргэдэг болох;
- ❖ Дотоод мэдээллийн аюулгүй байдлыг хангах тал дээр тавих хяналтын тогтолцоог илүү сайжруулах;

ЗАСАГЛАЛЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



М.Сэлэнгэ

ТАЙЛАНГ ХЯНАЖ БАТАЛСАН:

ТУЗ-ийн дарга



Д.Гэрэлмаа

2022 оны 1-р сар

“Говь” ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул
дүүрэг, Улаанбаатар-17062, Монгол Улс, Ш/Х 36/434

Утас: +976 7013-9977, Факс: +976 7014-3081
И-мэйл: info@gobi.mn